

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ



## “МУЗЕЙ ЦАХИМ ХУУДАС ХӨГЖҮҮЛЭЛТ” УРАЛДААНЫ УДИРДАМЖ

### Нэг. Зорилго

Соёлын дэд сайд, ойг тэмдэглэн өнгөрүүлэх Ажлын хэсгийн ахлагч П.Баттөрийн баталсан “Монгол Улсад орчин цагийн музей байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ”-ний нэгдсэн удирдамжийн 3.2, төлөвлөгөөний 15 дугаарт тус тус төлөвлөгдсөнийг үндэслэн музейн цахим хүртээмжийг нэмэгдүүлэх, сурталчилах зорилгын хүрээнд байгууллагуудын цахим хуудас (вэбсайт) хөгжүүлэлтийн ажлыг дүгнэх, шилдэг цахим хуудас (вэбсайт) хөгжүүлэлттэй байгууллагыг шалгаруулахад уралдааны зорилго оршино.

### Хоёр. Хамрах хүрээ

Уралдаанд төрийн болон орон нутгийн өмчийн музей, галерей, хувийн өмчийн музей, галерей хамрагдана.

### Гурав. Хугацаа

Уралдааныг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн хооронд зохион байгуулна.

### Дөрөв. Уралдаанд оролцоход шаардлагатай бүрдүүлэх материал

Оролцогч байгууллага нь дараах материалыг цаасан болон цахим хэлбэрээр 2024 оны 05 дугаар сарын 15-ны дотор Соёлын өвийн үндэсний төвийн Мэдээллийн технологийн газрын Программист Б.Шагж (утас: 98224591) shagj@ncch.gov.mn цахим хаягаар ирүүлсний үндсэн дээр тус уралдаанд оролцох эрх үүснэ.

Бүрдүүлэх материал:

- 4.1. Цахим хуудасны танилцуулга (бүтэц, цэс, талбаруудын тухай тайлбар);
- 4.2. Цахим хуудсанд байршуулсан мэдээлэл, контентын тоо (нийтлэл, катологи, гэрэл зураг, дүрс бичлэг гэх мэт);
- 4.3. Удирдамжийн 7-д заасан 6-н шалгуур үзүүлэлтийн холбогдох мэдээлэл;
- 4.4. Тухайн цахим хуудсыг хариуцсан албан хаагчийн холбоо барих мэдээлэл.

Жич: Оролцогч байгууллага нь цахим хуудастай байсны үндсэн дээр уралдаанд оролцох эрхээ авах ба хэрэв цахим хуудасгүй тохиолдолд шинээр үүсгэн, хөгжүүлснээр уралдаанд оролцох боломжтой болно.

#### **Тав. Цахим хуудсанд тавигдах шаардлага**

- 5.1. Оролцогчид цахим хуудас хөгжүүлэлтэд дараах стандартыг баримтална. Үүнд:
  - MNS 6285: 2017 Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага.
- 5.2. Цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байх. Үүнд:
  - Тухайн байгууллагын ерөнхий мэдээллүүдийг агуулсан байх (байгууллагын танилцуулга, бүтэц, үйл ажиллагааны чиглэл, цагийн хуваарь, холбоо барих мэдээлэл, хаяг, байршил, тасалбарын үнэ гэх мэт);
  - Тухайн байгууллагын лого, баннер, өнгө үзэмжийг агуулсан байх;
  - Цахим хуудас нь хэрэглэгчид ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байх.

#### **Зургаа. Шалгаруулалт**

- 6.1. Оролцогч байгууллага шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн ажлын тайланг цаасан болон цахим хэлбэрээр 2024 оны 09 дүгээр сарын 02-ны дотор Соёлын өвийн үндэсний төвд баталгаат шуудангаар ирүүлнэ.
- 6.2. Соёлын өвийн үндэсний төвийн захирлын баталсан Ажлын хэсэг болон “Музей цахим хуудас хөгжүүлэлт” уралдааныг дүгнэх Дэд ажлын хэсгийн гишүүд оролцогч байгууллагаас ирүүлсэн мэдээ тайланг хэлэлцэн, шалгуур үзүүлэлтийн дагуу 0-5 хүртэлх оноогоор дүгнэж, дүнг гаргана.
- 6.3. Шалгаруулалтыг тухайн оролцогч байгууллагын ирүүлсэн тайланд үндэслэн, цахим хуудсанд хийгдсэн хөгжүүлэлт, музейн үйл ажиллагааны чиглэлийн дагуу хийгдсэн ажил болон соёлын өвийг олон нийтэд түгээн дэлгэрүүлж, сурталчилсан байдлыг харгалзан үзэж шалгаруулна.
- 6.4. Цахим хуудас нь олон улсын, гадаад хэлэнд хөрвүүлэгддэг бол давуу тал болно.
- 6.5. Шалгаруулалтыг дүгнэж, шилдэг оролцогчдын шагналыг 2024 оны 11 дүгээр сард зохион байгуулах “Орчин цагийн музей үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хурал-Хүндэтгэлийн арга хэмжээ” дээр гардуулна.

#### **Долоо. Шалгуур үзүүлэлт**

- 7.1. Цахим хуудсанд цэс, талбар нэмэгдсэн байдал;
- 7.2. Цахим хуудсанд шинээр нэмэлт хөгжүүлэлт хийсэн байдал (тайлбар, мэдээлэл, салбар яам, агентлаг, холбогдох Соёл, урлагийн газартай цахим хуудас нь холбогдсон байдал);
- 7.3. Цахим хуудсанд байршуулсан мэдээлэл, контент (нийтлэл, катологи, гэрэл зураг, дүрс бичлэг гэх мэт) нэмэгдсэн байдал;
- 7.4. Цахим хуудсаар зочилсон хэрэглэгч болон хандалтын тоон дүн;

- 7.5. Цахим сүлжээний бусад платформ (Фэйсбүүк, Юүтүб, Инстаграм, Твиттер)-ийг цахим хуудсын хамт идэвхтэй хөтөлсөн байдал;
- 7.6. Цахим хуудас нь компьютер, гар утас, таблет болон бусад төхөөрөмжүүдийг дэмжин ажиллаж буй байдал.

#### **Найм. Дүгнэх аргачлал**

Дээрх 6 шалгуур үзүүлэлт тус бүр 0-3 оноогоор дүгнэнэ. Онооны нийлбэр нь 0-6 бол дунд, 7-12 бол сайн, 13-18 бол маш сайн гэж үнэлнэ. Маш сайн үнэлгээ авсан байгууллагуудыг онооны эрэмбээр тэргүүн болон тусгай байранд шалгаруулна.

*Жич: Маш сайн үнэлэгдсэн болон оноо тэнцсэн тохиолдолд цахим хуудасны хүртээмжтэй байдал, оновчтой шинэлэг санаачлагыг харгалзан уралдааныг дүгнэх Дэд ажлын хэсгийн гишүүд санал хураалтаар шийдвэрлэнэ.*

#### **Ес. Шагналын сан**

Шагналын сан 4.000.000 (дөрвөн сая төгрөг).

Тэргүүн байр – 1. Шагнал 2.000.000 төгрөг

Тусгай байр – 1. Шагнал 1.000.000 төгрөг

Тусгай байр – 1. Шагнал 1.000.000 төгрөг

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

---oO---